



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

Журмыг хариуцагч	Баримт бичгийн дугаар	Тушаалын дугаар/ Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Баталсан: Гүйцэтгэх захирал

ШИЛДЭГ АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

БЗӨБЦТС ТӨХК-Ж-000-015

Эх хувь	Дардас / тэмдэг
Хуулбар үнэн	
Хяналтгүй хувь	



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Өөрчлөлтийн бүртгэлийг энэхүү баримт бичигт өөрчлөлт оруулах хүсэлтэд үндэслэн хөтлөх ба энэ тохиолдолд өөрчлөлтийг эрх бүхий албан тушаалтан баталсан байна.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгд сэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

Нэг. Зорилго

- 1.1 Тухайн жилд компанийн тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшин нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг хангаж, үйлдвэрлэлийн осолгүй, аваари, saatlyg бууруулан, зорилтод түвшингийн үзүүлэлтүүдийг биелүүлж, ажилласан салбар, ажилтны ажлын үр дүнг урамшуулан үнэлэх, ажиллагсдын идэвхи, санаачилгыг өрнүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Тэргүүний салбарын ажлыг дүгнэж, шалгаруулах

- 2.1 Харьяа салбаруудын тухайн жилийн ажлын биелэлт, энэхүү журмын дөрөвт заасан үзүүлэлтийн дагуу компанийн “ОНЫ ТЭРГҮҮНИЙ САЛБАР”-ыг шалгаруулж байна.
- 2.2 Тэргүүний салбарыг тухайн жилийн эцсийн санхүүгийн тайлан баланс гарсаны дараа компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс ажлыг дүгнэж, байр эзлүүлэн шалгаруулна.
- 2.3 Салбарын ажлыг дүгнэх комиссын дарга шалгаруулалтын дүнг Захирлын зөвлөлийн хуралд танилцуулан зохих шийдвэрийг гаргуулна.
- 2.4 Харьяа салбаруудад тухайн жилийн ажлын үзүүлэлтээр нь “Хангалттай сайн”, “Хангалттай”, “Хангалтгүй” гэсэн үнэлгээ өгнө.
- 2.5 Тухайн жилийн ажлын үзүүлэлтээрээ “Хангалттай сайн” дүн авсан салбарыг 1-р байр эзлүүлэн, “Оны тэргүүний салбар”-аар шалгаруулж “ӨРГӨМЖЛӨЛ ” 1.000.000 /нэг сая/ төгрөгөөр, “Хангалттай” дүн үзүүлсэн нэг салбарыг 2-р байр эзлүүлж, “ӨРГӨМЖЛӨЛ ” 500.000 /таван зуун мянга/ төгрөгөөр тус тус шагнаж, урамшуулна.
- 2.6 Тухайн жил энэхүү журмын хавсралт-1-д заасан үзүүлэлтүүд болон доорхи нөхцлийг хангаж ажиллаагүй тохиолдолд тэргүүний салбар шалгаруулахгүй. Үүнд:
- 2.6.1 “Хангалттай сайн” үнэлгээ авсан байх.
 - 2.6.2 Үйлдвэрлэлийн осолгүй ажилласан байх.
- 2.7 “Тэргүүний салбар”-аар шалгарсан салбарын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, хангах, түгээх үйл ажиллагаа хариуцсан менежерүүдийг албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар, 2-р байр эзэлсэн салбарын дарга, ахлах нягтлан бодогч, эдийн засагч, хангах, түгээх үйл ажиллагаа хариуцсан менежерүүдийг албан тушаалын үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар тус тус шагнаж, урамшуулна.

Гурав. Оны хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аварга шалгаруулах, шагнаж урамшуулах

- 3.1 Компани жил бүр “... ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА”-аар 1 ажилтанг энэхүү журмын \Хавсралт№2\т заасан үзүүлэлтийн дагуу шалгаруулах бөгөөд дор дурьдсан ажил, мэргэжлийн аваргуудыг шалгаруулж байна. Үүнд:



ХУНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

- 3.1.1 “.... ОНЫ АВАРГА УДИРДАХ АЖИЛТАН. / Салбар, хэлтэс, албаны дарга /
- 3.1.2 “.....ОНЫ АВАРГА ЗАХИРГААНЫ АЖИЛТАН / хуулийн зөвлөх, хүний нөөцийн мэргэжилтэн, доотод ажил хариуцсан мэргэжилтэн, архив бичиг хэргийн ажилтан/
- 3.1.3 “... ОНЫ АВАРГА ИНЖЕНЕР”
- 3.1.4 “... ОНЫ АВАРГА ШУГА-НЫ ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР”
- 3.1.5 “... ОНЫ АВАРГА МАСТЕР БА ТЕХНИКЧ”
- 3.1.6 “... ОНЫ АВАРГА МОНТЁР” / засвар, ашиглалтын монтёрууд/
- 3.1.7 “... ОНЫ АВАРГА БАЙЦААГЧ МОНТЁР” /тоолуурын заалт авагч, авлага барагдуулагч нар энэ үзүүлэлтэнд хамрагдана./”
- 3.1.8 “... ОНЫ АВАРГА САНХҮҮ, ТОО БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН” /нягтлан бодогч, нярав, касс, данс хөтлөгч, оператор/
- 3.1.9 “...ОНЫ АВАРГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН” /жолооч,хангамжийн менежер, механик, жижүүр, үйлчлэгч/
- 3.1.10 “..ОНЫ АВАРГА МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН” /компьютер мэдээлэл сүлжээний ажилтан /
- 3.2 Харьяа салбар, алба, хэлтэс, хэсгээс ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон комисс энэхүү журмын хавсралт-1-12-т заасан үзүүлэлтуүдийн дагуу тухайн оны ажил, мэргэжлийн аваргуудыг шалгаруулан, дүнг Захирлын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулна.
- 3.3 Тухайн жил энэхүү журмын нийтлэг нөхцөлүүд болох 1-12-т заасан үзүүлэлтийг хангасан ажилтан шалгаргаагүй тохиолдолд ажил мэргэжлийн аль нэг аваргыг давхар тодруулах эсэх асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.4 Компанийн “ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА”-ыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ... дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар, “ОНЫ АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АВАРГА”-ыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар тус тус шагнаж, урамшуулна.
- 3.5 Тухайн жилийн “ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АВАРГА”-уудын зургийг компанийн хүндэт дэвтэрт байрлуулан алдаршуулна.
- 3.6 Ажилтны тухайн жилийн ажлын үзүүлэлт, харьяа салбар, алба, хэлтэс, хэсгийн дарга, менежерүүдийн саналыг харгалзан үзэж, гүйцэтгэх захирлын нэрэмжит өргөмжлөл, 100.000 /нэг зуун мянга/ төгрөг, СХҮАХ тэргүүн дэд , ТҮАХ,НҮАХ дэд захирлын нэрэмжит өргөмжлөл, 80.000 /наян мянга/ төгрөгөөр тус тус урамшуулж болно.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

Дөрөв. “ОНЫ ТЭРГҮҮНИЙ САЛБАР, ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ НИЙТЛЭГ НӨХЦЛҮҮД

- 4.1 “Оны тэргүүний салбар, хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аварга”-ыг шалгаруулахад доорхи нийтлэг нөхцлийг заавал хангасан байна. Үүнд:
- 4.1.1 “Оны хөдөлмөрийн аварга”-т компани болон салбарт 5-аас дээш жил ажилласан, урд өмнө нь ажил, мэргэжлийн аваргаар шалгарч байсан.
 - 4.1.2 “Оны ажил, мэргэжлийн аварга”-т 3-аас дээш жил ажилласан байх.
 - 4.1.3 Хариуцсан ажил, үүргийг сар, жилийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн байх.
 - 4.1.4 “Хөдөлмөрийн тухай” хууль болон хөдөлмөрийн гэрээ, дотоод журмыг чанд мөрдөж, хөдөлмөрийн зөрчил, сахилгын шийтгэлгүй ажилласан байх.
 - 4.1.5 Ажлын цаг ашиглалтын зөрчилгүй, олон нийтийн ажилд иdvæxtэй оролцож, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаварыг тухай бүр биелүүлж ажилласан байх.
 - 4.1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол /Үйлдвэрлэлийн осолгүй/, зөрчилгүй ажилласан байх.
 - 4.1.7 Компанийн дотоодын болон удирдах, дээд /ЭХГ, ТӨХ, МХГ, ЦБ гэх мэт/ байгууллагын хяналт шалгалтаар санхүүгийн болон худалдан авалтын зөрчилгүй ажилласан байна.
 - 4.1.8 Энэхүү журмын 4.1.1-4.1.7-д заасан нөхцлүүдийн аль нэгийг хангаагүй бол тэргүүний салбар, хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аваргаар шалгаруулахгүй.

Тав. Бусад заалт

- 5.1 Энэхүү журам нь гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 5.2 Оны хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аваргын тодорхойлолтыг жил бүрийн 12-р сарын 20-ны дотор компанийн захиргаа удирдлагын албанд ирүүлсэн байна.
- 5.3 “Оны тэргүүний салбар”-ын шагналыг жилийн эцсийн тайлан хамгаалалтан дээр, “Оны хөдөлмөрийн болон ажил, мэргэжлийн аварга”-уудын шагнал, урамшууллыг компанийн тухайн оны шинэ жилийн арга хэмжээ дээр хамт олны өмнө гардуулан өгнө.
- 5.4 Тэргүүний салбарын шагналыг хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулах.
- 5.5 Шаардлагатай гэж үзвэл журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж болно



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-1

ОНЫ ТЭРГҮҮНИЙ САЛБАР ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Оноо
1	Худалдан авсан цахилгаан эрчим хүч		сая. квт*ц			
2	Нийт алдагдал	Хувиар	%			
		Биетээр	сая. квт*ц			
3	Борлуулсан ЦЭХ		сая. квт*ц			
4	Нийт орлого		сая.төг			
5	Нийт зардал		сая.төг			
6	Ашиг, алдагдал		сая.төг			
7	Нийт авлага		сая.төг			
8	Нийт өр, төлбөр		сая.төг			
9	Технологийн зөрчил		тоо			
10	Их ба ургал засвар, ТЗБАХ-ний ажлын гүйцэтгэл		%			
Өгсөн үнэлгээ			Оноо			

ЖИЧ: Төлөвлөгөөг биелүүлсэн бол 1 оноо, ханган биелүүлээгүй бол 0 оноо өгөх бөгөөд 9-10 оноо авсан бол “Хангалттай сайн”, 6-8 оноо авсан бол “Хангалттай”, 0-5 оноо авсан бол “Хангалтгүй” гэсэн үнэлгээ өгнө.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-2

ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АВАРГААР ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил, үүргийг чанартай хийж гүйцэтгэж, ажлын үзүүлэлтүүд жилээс жилд сайжирсан байх	10	
2	Шинэ бүтээл, ашигтай загвар, дэвшилтэд саналыг \инноваци\ ажилд нэвтрүүлж, үр дүнд хүрсэн байх	1	
3	Ажиллаж буй чиглэлээрээ заавар, журам, дүрэм, гарын авлага, сургалтын материал боловсруулж олны хүртээл болгосон, залуу боловсон хүчнийг дадлагажуулж, сургасан /сургалт хийсэн/ байдал	1	
4	Компанийн санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллаж, тодорхой үр дүн хүрсэн байх	1	
5	Хариуцсан үүрэгт ажлын чиглэлээр техникийн дэвшилтээ технологийг ашиглан, тооцоо судалгаа хийж оновчтой горим, ажиллагааг ажилдаа нэвтрүүлэн үр ашиг гарган ажилласан байх.	1	
6	Компани салбар болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан спорт, урлаг, ажил мэргэжлийн тэмцээн уралдаанд идэвхтэй оролцож, шагналт байранд шалгарсан байх	1	



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

Нийт	15	
------	----	--

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-3

ОНЫ АВАРГА МАСТЕР БА ТЕХНИКЧ ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэж ажлын үзүүлэлтдэд жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	Өөрийн мэдлэг боловсролыг дээшлүүлсэн, мэргэжлийн дагуу сургалт, семинарт оролцсон, бусдыг сургаж, дадлагажуулсан байдал, шинэ бүтээл, ашигтай загвар, шилдэг шийдэл /инноваци/, техник, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг уртасгах болон алдагдлын хэмжээг бууруулах оновчтой шийдлийг ажилд нэвтрүүлсэн байх	1	
3	Хариуцсан дэд станц, ажлын байрны нөхцөл, эмх цэгц, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зохих шаардлагыг хангаж, үлгэр жишээ тохижуулсан байх	1	
4	Гэнэтийн болон болзошгүй аваари, saatlyн үед бэлэн байдлыг хангаж тасралтыг аваари, saatald хүргэхгүйгээр арилгаж их ба урсгал засвар, ТЗБАХ-ний ажлуудыг чанартай, аюулгүй зохион байгуулан технологийн зөрчил болон гэмтэлтэй тоноглолын тоог өмнө жилээс бууруулсан байх	1	
5	Ажил, үүргийн дагуу хөтлөгдвөл зохих бичиг баримт, паспортыг бүрэн хөтөлж, баяжилт хийж, баталгаажуулсан байх	1	



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

6	Хөдөлмөр хамгааллын 2,3-р шатны үзлэгээр зөрчилгүй /зөрчлийн тоог бууруулж/ ажилласан байх	1	
	Нийт	15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-4

ОНЫ АВАРГА БАЙЦААГЧ МОНТЁР ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэж ажлын үзүүлэлтдээ жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	Тооцоо судалгаатай ажиллаж, ЦЭХ-ний балансжилтыг хяналтын цэгүүдэд барьж ажилласан байдал	1	
3	Тоолуур болон бусад ЦТТ-ийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хангаж, гэмтлийн тоог өмнөх оноос бууруулсан байх	1	
4	Өөрийн ажил үүргийн онцлогт тохируулж, бүтээлч ажлыг нэвтрүүлсэн /øөй/ санаачилга, ашигтай загвар, Иnnovation хөтлөгдвөл зохих бичиг баримтыг зохих стандартын дагуу бүрэн хөтөлсөн байх	1	
5	Хэрэглэгчдэд үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой санал, гомдолгүй ажилласан байх	1	



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

6	Бичилтийн цэгийн тоо болон хэрэглээний өсөлт гарсан байх	1	
	Нийт	15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-5

ОНЫ АВАРГА МОНТЁР ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэж ажлын үзүүлэлтдэд жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	Хөдөлмөр хөнгөвчилсөн, цаг хугацаа хэмнэсэн, ЦТТ-ийн ашиглалтын түвшинг дээшлүүлсэн бүтээлч ажлыг санаачилж, ажилд нэвтрүүлсэн байдал	1	
3	Тухайн жилд гарсан аваари, саатал, гэмтлийг арилгах болон төлөвлөгөөт засварын ажлын гүйцэтгэлд оролцсон байдал	1	
4	Тухайн жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажилдаа ХАБЭА-гийн зөрчилгүй ажилласан байх	1	
5	Нарядаар хийгдсэн ажлын тоо, оролцсон байдал	1	
6	Тухайн жил өөрийн болон бусдын мэдлэг, боловсролыг дээшлүүлж, сурч, дадлагажсан байдал	1	
	Нийт	15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-6

ОНЫ АВАРГА САНХҮҮ, ТОО БҮРТГЭЛИЙН АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэж ажлын үзүүлэлтдэд жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	Мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, зохих дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, улирал болон жилийн татвар, шимтгэлийн зөрчилгүй ажилласан байх	1	
3	Дотоодын болон дээд байгууллагуудын ээлжит, ээлжит бус шалгалтаар зөрчил, дутагдалгүй ажилласан байх	1	
4	Тухайн жилийн бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан зардлын нэр төрлийг хэтрүүлээгүй, жилийн эцэст алдагдлыг бууруулж, ашгийг нэмэгдүүлж ажилласан байх	1	
5	Нийт авлага, өр, төлбөрийг тухайн оны зорилтод түвшингийн үзүүлэлтээс бууруулж ажилласан байх	1	
6	Тухайн жил өөрийн болон бусдын мэдлэг, боловсролыг дээшлүүлж, сургаж, дадлагажуулж ажилласан бай	1	
Нийт		15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-7

ОНЫ АВАРГА ИНЖЕНЕР ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэж ажлын үзүүлэлтдэд жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	ЦТТ-ийн ашиглалтын хугацааг уртасгах болон алдагдлын хэмжээг бууруулах шинэ бүтээл, ашигтай загвар, оновчтой шийдэл /инноваци/-ийг ажилд нэвтрүүлсэн байх	1	
3	Хариуцсан үүрэгт ажлын чиглэлээр дэвшилтэт технологийг нэвтрүүлж, тооцоо судалгаа хийн, оновчтой горим, ажиллагааг ажилдаа нэвтрүүлэн, үр ашиг гарган, эрчим хүчиний балансжилтыг хангаж, алдагдлыг бууруулсан байдал	1	
4	Өөрийн мэдлэг, мэргэжил, боловсролыг дээшлүүлсэн, мэргэжлийн дагуу сургалт, семинар зохион байгуулж оролцсон, бусдыг сургаж, дадлагажуулсан болон мэргэжлийн чиглэлээр эрх зүйн акт боловсруулахад оролцсон, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэл, өгүүлэл бичсэн байдал	1	
5	Ажил, үүргийн дагуу хөтлөгдвэл зохих бичиг баримт /паспорт, журнал/-ын хөтлөлт болон мэдээ, тайлан гаргалтыг боловсронгуй болгосон, ХХ-ын 3-р шатны үзлэгээр зөрчилгүй ажиллаж, ээлжит болон ээлжит бус шалгалтыг амжилттай өгсөн байх	1	
6	Сэргэжлүүлэх мэдээлэл – даалгавар, албан даалгаварын мөрөөр зохион байгуулсан ажлын биелэлт	1	
Нийт			15

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-8

ОНЫ АВАРГА УДИРДАХ АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХАД

ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Жилийн төлөвлөсөн ажлаа 100% биелүүлсэн байх.	2	
2	Хамт олоны дотороос сахилгын ноцтой зөрчил дутагдал гаргаагүй байна.	1	
3	Хамт олныхоо ажлын ачааллыг тэнцвэржүүлж цаг ашиглалтыг сайжруулж үр дүнд хурсэн байх.	1	
4	Шинэ дэвшилт технологийн оновчтой санал санаачлагыг ажилдаа нэвтрүүлсэн байх.	2	
5	Олон нийтийн ажилд хамт олноо болон өөрөө идвэхи санаачлагатай оролцсон байх.	1	
6	Хамт олны дотороос ХХАА-ны болон санхүүгийн зөрчил гаргаагүй, гэмт хэрэгт холбогдоогүй байх	2	
7	Ажиллагсдынхаа ажиллах ая тухтай орчинг бүрдүүлсэн байх.	1	
8	Ажиллагсдын нийгмийн асуудал, эрүүл мэндийн талаар санаачлагатай ажилласан байх.	1	
9	Удирдлагын менежментийг зөв хийх манлайллыг хангаж ажилласан байх	1	
10	Компанид мөрдөгдөж буй хууль, журам, дүрмийг хэрэгжүүлж ажилласан байх.	1	
11	Холбогдох хууль тогтоомж болон яам компаниас гаргасан дүрэм, заавар журмыг ажиллагсддаа танилцуулж мөрдөж хэвшүүлсэн байх.	1	
Нийт		15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-9

ОНЫ АВАРГА ЗАХИРГААНЫ АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Компанинд мөрдөгдөж байгаа хууль журам, дүрэм боловсруулахад идэвхи санаачлагатай оролцсон байх.	1	
2	Ажиллагсдын ажлын байрны тодохойролт, хөдөлмөрийн гэрээг хуулийн дагуу боловсруулсан байх.	2	
3	Компаний холбогдолтой өмч хөрөнгө , өр зээлийн асуудал болон хумүүлсийн хариуцлагатай холбоотой асуудлыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлсэн байх.	1	
4	Компанийн ажиллагсдын соён гэгээрүүлэх, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль журмыг танилцуулсан байх.	1	
5	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, төрөл бүрийн судалгааг гаргаж , үнэлэлт дүгнэлт өгч, ажиллагсдын хувийн хэрэг карт хөтлөлтийг стандартын дагуу хийсэн байх.	2	
6	Гарч байгаа боловсон хүчинтэй холбоотой тушаал , заавар журамын үндэслэл бичилтийг зөв хийж гаргасан байх.	1	
7	Бичиг хэргийн стандартыг хэрэгүүлж ажилласан байх.	1	
8	Ирсэн, явуулсан хугцаатай албан бичгийг бүртгэж, цаг хугацаанд нь хариу явуулж бүртгэж байх.	1	
9	Бичиг хэргийн эргэлттэй холбоотой тооцоо судалгааг гаргасан байх.	1	
10	Архивын бичиг баримтын хадгалалтыг стандартын дагуу байршуулж тохижуулсан байх.	1	
11	Дотоод ажлыг дүрэм журмын дагуу дагуу хийж хэвшсэн байх.	2	
12	Компаний ажиллагсдынг идвэхжүүлэх зорилгоор олон нийтийн арга хэмжээг Төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хамт олныг оролцуулсан байх.	1	
13	Ажиллагсдын болон өндөр настан, хүүхдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай ажилласан байх. /хүүхдийн зөвлөл/	1	



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

14	Хөдөлмөрийн гэрээнд хүлээсэн үүргээ болон хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлж, харилцаа, ёс суртахууны зөрчилгүй ажилласан байх.	2	
	Нийт	15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.

БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-10

ОНЫ АВАРГА ШУГА-НЫ ЭЭЛЖИЙН ИНЖЕНЕР ШАЛГАРУУЛАХАД

ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Аваари устгах, сэлгэн залгалтын үйлдэл хийх ажлын явцад ямар нэгэн алдаа гаргаагүй байх	1	
2	Журнал бичиг баримт хөтлөлт, эмх цэгц, ажлын байрны ариун цэвэр	1	
3	Шуурхай ажиллагааны ажлын зохион байгуулалт, Хяналт мэдээллийн систем мөрдөлт, рапорт мэдээ өгөлт	1	
4	Өдөр тутам ажлын явцад зөрчил дутагдал, аюултай байдлыг илрүүлж арилгасан, таслан зогсоосон байдал	1	
5	Ашигтай загвар, оновчтой шийдэл, шинэ бүтээл /инноваци / нэвтрүүлсэн байдал	1	
6	Үзлэгийн чанар /гэмтэл илрүүлж арилгасан байдал/ ЦТТ-ийн засвар үйлчилгээ, өнгө үзэмж, тэмдэг тэмдэглэгээ	1	
7	Ажлын хувцас, багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хэрэглээ	1	
8	Ажлын цаг ашиглалт	1	
9	Олон нийтийг хамарсан нийгмийн ажилд идэвхи санаачлагатай оролцсон байдал	1	
10	Мэдээ тайлан гаргалт, үүрэг даалгаврын биелэлт	1	
	Нийт дүн	10	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-11

ОНЫ АВАРГА МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН ШАЛГАРУУЛАХАД ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил, үүргийг чанартай хийж гүйцэтгэж, ажлын үзүүлэлтэд жилээс жилд ахиц гарсан байх	2	
2	Холболтын төхөөрөмжүүдийн найвартай ажилгаа болон шинэ тоног төхөөрөмж нэвтрүүлсэн байх	2	
3	Хариуцсан үүрэгт ажлын чиглэлээр дэвшилт технологийн нэзврүүлж, тооцоо хийж оновчтой санал, ажилдаа нэвтрүүлсэн байх	1	
4	Өөрийн мэдлэг, мэргжил, боловсролыг дээшлүүлж мэргэжлийн дагуу сургалт семинар зохион байгуулж оролцсон байх	1	
5	Ажил, үүргийн дагуу хөтлөгдвэл зохих бичиг баримт /паспорт, журнал/ыг хөтлөн ажилсан байх	1	
6	Ажлын үүрэг –даалгавар, албан даалгаварын мөрөөр зохион байгуулсан ажлын биелэлт	1	
7	Компанийн, хувь хүний нууцыг хадгалах сайтын бүрэн бүтэн байдлыг хариуцах.	1	
8	Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байх	2	
9	Ажлын цаг ашиглалтыг сайжруулж зөрчил дутагдалгүй ажилласан байх	1	
10	Үдиридлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь биелүүлсэн байх	1	
	Нийт	15	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-12

ОНЫ АВАРГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАН” ШАЛГАРУУЛАХАД

ХАРГАЛЗАХ ҮЗҮҮЛЭЛТ /ЖОЛООЧ/

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо	Авсан оноо
1	Сүүлийн хоёр жил тасралтгүй өөрийн хариуцсан ажил, үүргийг чанартай хийж гүйцэтгэж, ажлын үзүүлэлтэд жилээс жилд ахиц гарсан байх	10	
2	Замын хөдөлгөөний осол, зөрчилгүй ажилласан байх	1	
3	Хариуцсан автомашин механизмын засвар, техник үйлчилгээг чанартай хийж хэвшсэн, жолоочийн тооцоог сар бүр бүрэн өгч, өр төлбөргүй ажилласан байх.	1	
4	Өөрийн санаачилгаар хариуцсан машин механизмын ашиг ёалтыг сайжруулах бүтээлч ажил хийсэн, автомашин, механизмын бэлэн байдлыг хангаж ажилласан байдал.	1	
5	Компанид нийлүүлж байгаа сэлбэг, бараа материал нь чанарын шаардлага хангасан байх ба цаг хугацаанд нь нийлүүлсэн байх	2	
6	Компанид шаардлагатай байгаа сэлбэг материалын тендерийг цаг хугацаанд нь зарлаж урсгал болон их засварын үед материал сэлбэгийг цаг тухай бүр нийлүүлсэн байдал	1	
7	Автомашины гүйлт, механизмын мото*цаг-ийг төлөвлөсөн хэмжээнээс давуулан биелүүлсэн байх.	1	
8	Шугам дэд станцын тоног төхөөрөмжийн их, урсгал засварын ажлын төсөвийг цаг тухайд нь хийж сэлбэг материалыар хангасан байх	1	
9	Сэлбэг, шатах, тослох материалын зардлыг хэмнэж ажилласан байх.	1	
10	Ажлын албан конторын цэвэрлэгээг тогтмол чанартай хийж гүйцэтгэсэн байх.	1	
Нийт		20	

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-13

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕР НАРЫГ ШАЛГАРУУЛАХ ТУСГАЙ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо /1-5/
1	Төлөвлөгөөт ажлын биелэлт 100% гүйцэтгэлтэй байх.	
2	Сургалт явуулах шинэлэг арга барилыг нэвтрүүлж үр дүнд хүрсэн байх	
3	Ажлын байрны сургалтыг тогтмолжуулан бүтээлч ажлыг хийж нэвтрүүлсэн байх	
4	ИТА, монтёруудыг шинээр сургах шинэ арга зүйг нэвтрүүлсэн байх.	
5	Ажиллагсдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг хуулийн дагуу боловсруулсан байх.	
6	Сургалтын кабинетийг тохижуулж сар бүр сургалтыг тасралтгүй зохион байгуулсан байх.	
7	Ажиллагсдын хувийн хэргийг стандартын дагуу хавтаслан товьёог хийж дугаарлан баяжилтыг хийсэн байх.	
8	Ажиллагсдын нийгмийн асуудлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэсэн байх.	
9	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, төрөл бүрийн судалгааг үнэн зөв гаргаж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан байх.	
10	Гарч байгаа боловсон хүчинтэй холбоотой тушаалыг хуульд нийцүүлэн эрх зүйн актыг зөв үндэслэн гаргах, заавар журмын үндэслэл бичилтийг зөв хийж, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандартыг хэрэгжүүлж ажилласан байх	
11	Компаний ажиллагсдынг иdvэхжүүлэх зорилгоор олон нийтийн арга хэмжээг Төр захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хамт олныг оролцуулсан байх.	
12	Хөдөлмөрийн гэрээнд хүлээсэн үүргээ болон хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлж, харилцаа, ёс суртахууны зөрчилгүй ажилласан байх.	
Нийт		

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ-2018

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн ХНБББ-ийн Ж-000-015-ын Хавсралт-14

БИЧИГ ХЭРЭГ, АРХИВЫН АЖИЛТАН НАРЫГ

ШАЛГАРУУЛАХ ТУСГАЙ ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Авбал зохих оноо /1-5/
1	Төлөвлөгөөт ажлын биелэлт 100% гүйцэтгэлтэй байх.	
2	Хөдөлмөрийн гэрээнд хүлээсэн үүргээ болон хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлж, харилцаа, ёс суртахууны зөрчилгүй ажилласан байх.	
3	Байгууллагаас гарч байгаа албан бичгийг , албан хэрэг хөтлөлтийн зааварт заасан чиг үүргийн дагуу зөв хийж стандартын дагуу гаргасан байх.	
4	Иргэд, ажиллагсдаас ирсэн өргөдөл гомдлыг цаг тухайд нь бүртгэж удирлагад танилцуулж хариуг нь хуулийн хугацаанд нь явуулж нэгдсэн бүртгэл гаргасан байх.,	
5	Байгууллагт ирсэн, явуулсан хугаатай албан бичгийг бүртгэж, цаг хугацаанд нь хариу явуулж бүртгэж байх.	
6	Бичиг хэргийн эргэлттэй холбоотой тооцоо судалгааг гаргасан байх.	
7	Архивын бичиг баримтын хадгалалтыг стандартын дагуу байршуулж тохижуулах, архивт хадгалагдаж байгаа бичиг баримтыг ангилан жагсаалт гаргасан байх.	
8	Устгах материалыг баримт бичиг нягтлан шалгах комисст оруулан устгал хийж бүтгэл хийсэн байх.	
Нийт		

ЖИЧ: Хамгийн өндөр оноо авсан ажилтныг шалгаруулна.